



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/155

Алтанбулаг

Мал амьтны гоц халдварт шүлхий өвчин,
үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалт хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.12, Сэлэнгэ аймгийн Онцгой комиссын 2022 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн 05 тоот хуралдааны тэмдэглэл, сумын Засаг даргаас аймгийн Засаг даргатай 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан “Хариуцлагын гэрээ”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчин, үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг уг өвчинд мэдрэмтгий мал сүрэгт 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 10 хоногийн хугацаанд шуурхай, чанартай зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, шаардлагатай шатахууны зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар, дархлаажуулалтын замын маршрутыг 3 дугаар хавсралтаар, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодис бусад материалын тооцоог 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.


3. Дархлаажуулалтын үйл ажиллагааг батлагдсан хуваарийн дагуу, технологийн хугацаанд нь шуурхай, чанартай зохион байгуулж, тайлан мэдээг хүргүүлэн хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Х.Отгонжаргал)-д даалгасугай.

4. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийг малын хөлийн татварын орлогоор санхүүжилт хийх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан шийдвэрлүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан (Р.Насанжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.ОТГОНЦОГТ

Алтанбулаг сумын Засаг даргын 2022 оны
04 дугаар 18 -ны өдрийн А/55 дугаар тоот
захирамжийн 01 дүгээр хавсралт



Мал амьтны гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалын ажлын хэсэг

Ажлын хэсгийн дарга: Х.Отгонжаргал
(Засаг даргын орлогч)

Нарийн бичиг: М.Цэгмид
(Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)

Гишүүдэд: Б.Буян-Өлзий
(Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Ц.Отгонпүрэв
(Жолооч)

Р.Булгаа
(“Бөхлөө Хангай” МЭҮН-н малын эмч)

Ё.Эрдэнэцогт
(Жолооч)

Л.Алтансүх
(Мал баригч)

С.Мөнхтөр
(Мал баригч)

Л.Гантөмөр
(“Бумбат Өлгий” МЭҮН-н малын эмч)

Ч.Энхтөр
(Жолооч)

Э.Анхбаяр
(Мал баригч)